# ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТЭС Н.ЦОЛМОНБАЯРЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь | Төсвийн ерөнхийлөн захирагчийн үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.** | | | | | | | | |
| "Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | | |
| 1.1.2 | Нийгмийн даатгалын сайн дураар даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх, малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг 24%-иас доошгүй хувьд хүргэх, хөдөлмөрийн гэрээ бүхий туслах малчныг бүрэн хамруулах. | Үйл ажиллагааны зардлаар | Шинээр хамруулсан даатгуулагчдын тоо | 2024 онд нийт 4969 сайн дурын даатгуулагч хамрагдсанаас 2286 нь малчин даатгуулагч. | Сайн дураар даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх, малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг 12%-иас доошгүй хувьд хүргэж ажиллана. | Нийт **4990** иргэн сайн дурын даатгал хамрагдсан байна.<br>Үүнээс **2470** даатгуулагч шинээр хамрагдсан.<br>- Энгийн сайн дурын даатгуулагч хамрагдсан нийт **1486** бөгөөд шинээр 762 даатгуулагч<br>- Сайн дурын даатгалд хамрагдсан малчдын тоо нийт **2736** бөгөөд шинээр **1591** малчин хамрагдсан.<br>- 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн даатгалд нийт **671** даатгуулагч хамрагдсанаас шинээр **83** даатгуулагч хамрагдсан.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асраж байгаа эцэг, эхийг даатгалд нийт **97** даатгуулагч хамрагдсанаас шинээр **34** даатгуулагч хамрагдаад байна. | 100% | |
| ***Биелэлт – 100/1 100 %*** | | | | | | | | |
| **Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | | |
| "Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | | |
| 2.1.9 | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд | Нийгмийн даатгалын газрын дэргэдэх | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагаар хууль | а. НДЕГ-ын 2025 оны 04 сарын 15 өдрийн №02/138 албан бичгийн дагуу үндсэн хөрөнгө актлах саналыг | 95% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан. | өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2024 онд 1 удаа хуралдаж үндсэн хөрөнгийн элэгдлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх болон цаашид ашиглах боломжгүй, өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг актлах саналыг хэлэлцэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2023 оны хийсэн ажлын гэрээ дүгнэж тус газар нь 94 хувьтай дүгнүүлсэн. Түрээсийн гэрээ байгуулж ажилладаггүй болно. | дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах.<br>-Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх.<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах. | холбогдох бичиг баримтын хамт НДЕГазарт хүргүүлсэн. Тоног төхөөрөмж 2,3 сая төгрөг , тавилга эд хогшил 0,8 сая төгрөг, барилга 0,9 сая төгрөг нийт 4,0 сая төгрөг байна.<br>б. ТӨ1-ТӨ11 , ТӨХ маягтыг НДЕГазрын Санхүү бүртгэлийн газарт хугацаанд нь хүргүүлсэн.<br><br>в. Тус газар нь үндсэн хөрөнгө, эд хогшлын тооллогыг хагас бүтэн жилээр хийж гүйцэтгэдэг бөгөөд 2025 оны хагас жилийн байдлаар эд хөрөнгийн тооллого хийх ажил бэлтгэл шатандаа явж байна.<br><br>г. Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажилладаг бөгөөд НДЕГ-ын 2025 оны 03 сарын 29 өдрийн № 01/707 албан тоотын дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын burtgel.gov.mn сайтад 2024 оны хөрөнгийн хөдөлгөөн, санхүүгийн мэдээ, мэдээллийг 2025 оны 04 сарын 07-ний өдөр байршуулан баталгаажуулсан.<br><br>д. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан гэрээ дүгнэх хугацаа болоогүй байна. Түрээсийн гэрээ байгуулж ажилладаггүй болно. | | |
| ***Биелэлт – 95/1 95%*** | | | | | | | | |
| **Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | | |
| "Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | | |
| 3.1.1 | Нийгмийн даатгалын сан болон үйл | | Батлагдсан удирдамжийн | Батлагдсан удирдамжийн | Хяналт шалгалтаар тогтоосон төлбөр | Захиргаа хяналтын хэлтэс нь 2025 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөө, | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны хэрэгжилтэд дээд шатны байгууллагаас ирүүлсэн чиглэлийн дагуу дотоод аудит хийх; | | дагуу дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтын үр дүнг Хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, баталгаажуулан тайланг Дотоод аудит, мониторингийн газарт хүргүүлсэн байна. | дагуу дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дүнг нийгмийн даатгалын газрын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэн тайлагнасан байна. | зөрчил, албан шаардлага, хугацаатай үүрэг даалгавар, бүрэн барагдсан байх. | удирдамж гарган газрын даргаар батлуулж, нийгмийн даатгалын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар чиглэлийн дагуу дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дотоодын хяналт шалгалтын хүрээнд мэдээллийн нэгдсэн баазад бүртгэлтэй ажил олгогчийн 20 хүртэл хувийг шалгах, тэтгэвэр, тэтгэмж авагчдын 2024 оны тэтгэврийн олголтыг шалгах, 2024 оны сангийн болон үйл ажиллагааны баримтыг хүлээн авах, баримтын бүрдэлд хяналт шалгалт хийх, Сайн дурын даатгалын 2024 оны хамралт, шимтгэл ногдуулалт, мэдээллийн баазын баяжилт, хуулийн хэрэгжилтийг шалгах, Сумдын дотоод ажлыг шалгах, зөрчил дутагдлыг арилгах, зөвлөгөө мэдээллээр хангах, гадагшаа чиглэсэн хяналт шалгалтад хяналт тавих, НДЕГ бусад дээд шатны байгууллагаас ирүүлсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамрагдах ажлуудыг тусган Дадал, Норовлин, Галшар сумдад хяналт шалгалт хийн, өртэй ААНБ-д акт алданги тооцон, төсөвт байгууллагатай уулзалт зохион байгуулж зөрчлийг арилган, чиглэл өгч, газрын даргад танилцуулсан. | | |
| 3.1.2 | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтэд аудит хийх; | | Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд | 2024.01.01 - 2024.11.30-ны хүртэлх хугацааны Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр дотоод аудит хийсэн. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулсан байна. | Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай 03 тоот албан даалгаврын хүрээнд Дотоод аудит мониторингийн газраас Шилэн дансны мэдээлэл байршуулалтад 2025 оны 01 дүгээр улирлын байдлаар хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийгмийн даатгалын сангийн нийт 43 мэдээллийг үнэн зөв хугацаанд нь байршуулж 100%-тай, үйл ажиллагааны | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг баримталсан байна. | | | мэдээлэл байршуулалт нийт 46 мэдээллийг үнэн зөв 100%-тай байршуулж, хугацаандаа мэдээлсэн 38, хугацаа хоцорсон 8 мэдээлэл байршуулж 83%-тай үнэлэгдсэн байна. 2025 оны хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын сангийн нийт 63 мэдээлэл байршуулахаас 63 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт нийт 67 мэдээлэл байршуулахаас 66 мэдээллийг хугацаандаа байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Шилэн дансанд байршуулсан мэдээлэлд хяналт тавин улирал бүр тайлан мэдээг Дотоод аудит мониторингийн газарт хүргүүлэн ажиллаж байна. | | |
| “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | | |
| 3.2.1 | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэл болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу гадаад болон дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах. | | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах арга хэмжээ авах, | Шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгах. | Шалгалтын үр дүнг улирал тутамд тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 50-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Гадаад болон дотоодын хяналт шалгалтын удирдамжийн дагуу Дадал, Норовлин, Галшар сумын 2024-2025 оны НДШ төлөлтийн тайлан, тооцоо, СДД-н гэрээ, үндэслэл, үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг шалгах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголт, дотоод ажлын чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажил, гарч байгаа алдаа зөрчлийг шалгасан. Шалгалтаар Норовлин сумын Онон улз ХХК, Галшар сумын Алтат ам ХХК-д нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2-т заасны дагуу алданги тооцон төлбөр, зөрчлийг барагдуулан ажилласан. Ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт зэрэг бүртгэл хөтлөлтгүй, сайн дурын даатгуулагчийн гэрээг дутуу хэвлэж баримтжуулаагүй зөрчил гарсан. Дадал сумын цэргийн | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ӨНТ авагч, ТАТ авагч нарын тэтгэврийн хувийн хэрэг алга болсон тул нөхөн бүрдүүлэхээр, цаашид алдаа дутагдал гаргахгүй байхад анхаарч ажиллах зэрэг үүрэг даалгавар өгч ажилласан. | | |
| 3.2.2 | Хэнтий аймгийн нийгмийн даатгалын газрын тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэг, хавсаргасан холбогдох үндсэн баримтын тооллогыг хагас, бүтэн жилд хийж, тэтгэвэр олгосон файл, жагсаалттай тулган шалгаж баталгаажуулах, | | Идэвхтэй, зогсоогдсон, нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж үр дүнг тооцох, | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг хагас, бүтэн жилээр бүрэн хийж тайланг нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан тэтгэврийн хувийн хэргийн тооллогын дэлгэрэнгүй бүртгэлийн нэгтгэл /ЗН-НД-6/, тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогын нэгтгэл /ЗН-НД-7/ маягтаар актыг 2 хувь үйлдэж, тухайн улирал, жилийн эцэст байвал зохих тэтгэвэр авагчийн тоог хувийн хэрэг, олгосон тэтгэврийн дүнтэй тулган баталгаажуулсан байна. | Нийгмийн даатгалын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогын комиссыг хэрлэн суманд газрын даргын тушаалаар, сумдад сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг 2025 оны 04 дүгээр сарын 08-10-ний өдрүүдэд зохион байгуулж тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан тэтгэврийн хувийн хэргийн тооллогын дэлгэрэнгүй бүртгэлийн нэгтгэл /ЗН-НД-6/, тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогын нэгтгэл /ЗН-НД-7/ маягтаар актыг 2 хувь үйлдэж, тэтгэвэр олголтын жагсаалттай тулган шалгасан. Шалгалтаар нийт тоологдвол зохих тэтгэврийн хувийн хэргээс тоологдсон 13924 үүнээс ӨНТ-11172, ХЧАТ-2054, ТАТ-692 тэтгэврийн хувийн хэрэг тоологдсон байна. Дадал сумын 2, Баянхутаг сумын 1 тэтгэвэр авагчийн хувийн хэрэг алга болсон тул нөхөн бүрдүүлэхээр, цаашид алдаа дутагдал гаргахгүй байхад анхаарч ажиллах зэрэг үүрэг даалгавар өгч ажилласан. Мөн тэтгэврийн хувийн хэргийн баяжилтыг бүрэн хийж дуусгасан байна. | 100% | |
| 3.2.3 | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн | | Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, | Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу | Нийгмийн даатгалын газар нь Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу тус газарт ирсэн гомдол мэдээллийг шалган | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангаж ажиллах. | | хяналт тавих, эрх бүхий албан тушаалтныг томилж тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцох, | заасны дагуу 1 байгууллагыг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгон шийдвэрлэсэн.Торгуулийг бүрэн барагдуулсан. | хариуцлага тооцож, шийттэлийн хуудсаар төлүүлэхээр шийдвэрлэсэн торгуулийг 80 хувь, шимтгэл, алдангийг 50-аас доошгүй хувиар барагдуулсан байна. | тус хуульд заасан зүйл заалтын дагуу холбогдох арга хэмжээг авч зөрчилд хамаарах баримт материалыг прокурорын газраар хянуулан төлүүлэхээр шийдвэрлэсэн торгууль, шимтгэл, алдангийг тухай бүр барагдуулах ажлыг зохион байгуулан хуулийн хэрэгжилтийг ханган ажилладаг. 2025 оны хагас жилийн байдлаар Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгонд үйл ажиллагаа явуулдаг Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, Хүүхдийн цэцэрлэг, Амжилтын ташуур НҮТББ-тай холбоотой зөрчилд Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1, 4.8 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон холбогдогчоос мэдүүлэг авч, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, тухайн ажил олгогч тус бүрийг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.4-т заасны дагуу хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгон, нийт 1.0 сая төгрөгийн торгуулийг 100%-тай барагдуулан ажилласан. | | |
| 3.2.4 | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэлийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр | | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн | Дотоодын хяналт, шалгалтын төлбөр зөрчлөөр 7.2 сая төгрөгийн төлбөр зөрчил нэмэгдэж, нийт 45.4 сая төгрөг болсон. Үүнээс 18.4 сая төгрөгийг барагдуулан ажилласан байна. | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 50-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | 2025 оны хагас жилийн байдлаар гадаад болон дотоодын хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн оны эхний үлдэгдэл 111.5 сая төгрөг, шалгаж илрүүлсэн 30.9 сая төгрөг, нийт 142.4 сая төгрөгөөс 50.7 сая төгрөгийг барагдуулан 91.7 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Хяналт, шалгалтын тайланг улирал бүр үнэн зөв гарган дээд шатны байгууллагад тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.<br>Тэтгэврийн тогтоолт, олголттой холбоотой илүү олгосон 29 тэтгэвэр авагчийн 83.3 сая төгрөг, Тэтгэмжийн тогтоолт олголттой холбоотой 28 даатгуулагчийн 7.0 сая төгрөг, үйл | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх. | | хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт ирүүлэх, | | | ажиллагааны зардлын зарцуулалттай холбоотой 1 даатгуулагчийн 0.4 сая төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлттэй холбоотой 1 байгууллагын 0.01 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр, 4 даатгуулагчийн 1.0 сая төгрөгийг нөхөн олгохоор байна. Нэгтгэсэн тайлангаас үзэхэд дээд шатны байгууллагаас илэрсэн төлбөр зөрчил нь 60.6 хувийг эзэлж байна. Хяналт шалгалтын дүнг нэгтгэн сумдын байцаагч болон Хэлтсийн дарга нарт танилцуулсан. | | |
| ***Биелэлт – 600/6 100%*** | | | | | | | | |
| **Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.** | | | | | | | | |
| "Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | | |
| 4.1.1 | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлсэн эсэх | Тайлан, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хугацаанд нь хүргүүлсэн. | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | Тус газар нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан мэдээтэй тухай бүр танилцаж Нийгмийн даатгалын газрын нэгжийн чиг үүрэгтэй холбоотой 36 мэдээ, тайланг цаг хугацаанд нь дээд шатны байгууллагат хүргүүлж ажилласан байна. | 100% | |
| 4.1.2 | ААНБ, иргэд, | | Өргөдөл | 2024 онд ажил | Засгийн газрын "Иргэд | Тус газарт ирсэн өргөдөл гомдлыг | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | | гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | олгогч, иргэн даатгуулагчаас 165 өргөдөл, гомдол ирснээс 165 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн ажилласан. | олон нийттэй харилцах төв"-д болон иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, тэдний тавьсан санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах. | төвлөрсөн журмаар хүлээн авч, амаар гаргасан өргөдөл, гомдлыг тэмдэглэн авч, тусгай бүртгэлд бүртгэдэг. Өргөдөл гомдлыг удирдлагад танилцуулан цохолт хийлгэж, бүртгэлийн карт хөтөлж шийдвэрлэх албан тушаалтанд ирсэн өдөрт нь багтаан шилжүүлж, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд Захиргаа, хяналтын хэлтсийн дарга буюу бичиг хэргийн ажилтан хяналт тавин ажилладаг. Бүртгэл мэдээллийн өгөгдлийн санг ашиглан, өргөдөл гомдлын шийдвэрлэлт ямар шатандаа байгаа болон хэзээ хэрхэн шийдвэрлэгдэх талаар иргэдэд шуурхай мэдээллийг хүргэж ажилладаг. Эхний хагас жилийн байдлаар иргэд, даатгуулагчдаас тэтгэвэртэй холбоотой өргөдөл 3, НДШ төлөлттэй холбоотой бичиг 46, чөлөө авах хүсэлт 3, шилжин ажиллах хүсэлт 4, ажлаас чөлөөлөгдөх 2, ажилд орох 1, урьдчилан цалин авах өргөдөл 1, регистрийн дугаар солих 3, лавлагаа авах 1, ЖА тэтгэмж авах тухай 1, Ажилгүйдлийн тэтгэмж авах 1, нийт 66 өргөдлийг хүлээн авсан байна. Үүнд: 64 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хугацаа болоогүй 2 өргөдөл шийдвэрлэгдээгүй хүлээлтийн төлөвт байна. НДЕГ-аас тус газарт ирүүлсэн 02/1088 албан тоотын дагуу өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээллийг хавсралт хүснэгтийн дагуу гарган улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор НДЕГ-ын ДАМГ хүргүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар 2025 оны 01 дүгээр улирлын өргөдөл гомдлын тайланг НДЕГ-т, Хэнтий аймгийн ЗДТГ-т хуулийн хугацаанд шийдвэрлэж дээд шатны байгууллагат хавсралт хүснэгтийн дагуу хүргүүлэн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан байна. | | |
| 4.1.3 | Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх. | | Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрууд архивын лавлагааг газар хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулах. | 2024 оны жилийн эцсийн байдлаар тус газарт 562 лавлагааны хүсэлт ирж, 533 иргэн, байгууллагад нийгмийн даатгалын төрөлжсөн архивын лавлагааг олгосон байна. | Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн байна. | Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар тус газарт 310 лавлагааны хүсэлт ирж, 368 иргэн, байгууллагад нийгмийн даатгалын төрөлжсөн архивын лавлагааг олгосон байна. | 100% | |
| 4.1.4 | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байх. | | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, тайланг үнэн зөв гаргаж хүргүүлэх. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан орон тооны дээд хязгаарыг хэтрүүлэлгүй ажилласан. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргасан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан орон тооны дээд хязгаарыг хэтрүүлэлгүй ажилласан. 2025 оны хагас жилийн байдлаар төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн 4 албан хаагч, давхар ажил гүйцэтгүүлэхээр 1 албан хаагчийг тус тус томилсон. Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо /8 удаа/ гарсныг тухай бүр аймгийн салбар зөвлөлд хүргүүлэн ажилласан. Газрын албан ёсны facebook хуудас болон Хэнтий аймгийн ЗДТГ-ын албан ёсны сайтуудад сул орон тооны зарыг нийтэд тогтмол мэдээлэн ажиллаж байна. | 100% | |
| 4.1.5 | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх. | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүрэг, ажлын байрны үндсэн зорилтыг | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр 2 шинэлэг ажлыг зохион байгуулан ажилласан. | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна. | Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг нэг цэгээс хөнгөн шуурхай хүргэх, зорилгоор тус байгууллагад киоск машин байршуулснаар нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн тодорхойлолт, тэтгэврийн эрх үүсээгүй тодорхойлолт, нэрийн дансны лавлагаа....гэх мэт 18 төрлийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай авах боломж бүрдсэн. | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | давхардуулах гүй байх, ажлын байрны гол үйл ажиллагааг тодорхой болгох. | | | | | |
| 4.1.6 | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | | Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлаар судалгаа хийх, бүртгэлжүүлэх, тусламж үзүүлэх. | Төрийн албаны тухай хуулийн хүрээнд 10 байцаагч шинээр зэрэг дэвийн нэмэгдэл олгох, 10 байцаагчийн зэрэг дэвийг ахиулахаар холбогдох материалыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, захирамж гаргуулан нэмэгдлийг зохих ёсоор тооцон олгож байна. 3 байцаагчийн цалингийн шатлалыг ахиулсан байна. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг бүрэн тайлагнасан байна. | Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан ажиллах орчныг сайжруулах, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд зэрэг дэв олгох, ахиулах боломж шаардлага хангасан төрийн албан хаагчдын мэдээ судалгааг гарган, албан хаагчдын хувийн хэргийг шинэчилж гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаа.<br>Төрийн албаны тухай хуулийн хүрээнд 2 байцаагч шинээр зэрэг дэвийн нэмэгдэл олгох, 4 байцаагчийн зэрэг дэвийг ахиулахаар холбогдох материалыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, захирамж гаргуулан нэмэгдлийг зохих ёсоор тооцон олгож байна.<br>Мэргэжлийн "Зөвлөх" зэрэгтэй 2, "Итгэмжит" зөвлөх зэрэгтэй 5 байцаагчид тус тус НДЕГ-с ирсэн тушаалын дагуу нэмэгдлийг олгож байна.<br>Төрийн албаны тухай хууль болон дотоод журамд заасны дагуу 3 албан хаагчид 1.5 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.<br>Нийгмийн даатгалын газрын 26 ахмадад цагаан сарын баяраар 1,300 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. | 100% | |
| 4.1.7 | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон | Ажилтан, албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 1 удаа зохион | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаанда а мөрдөж ажилласан байна. | хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтыг зохион байгуулан ажилласан байна. | дээшлүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж хэвшсэн байна. | байгуулж НДЕГазар болон АЗДТГазраас зохион байгуулж байгаа "Нэг цаг, нэмэх цэнэг" сургалтад цахимаар 2 удаа хамрагдаж нийт 46 албан хаагч хамрагдсан. “Стресс менежмент” сэдвийн хүрээнд сургагч багш М.Гэрлээ 2025.04.10-нд 23 байцаагч, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орон нутагт ажиллаж амьдрах эрхийн баталгааг хангахад анхаарах асуудлыг тодорхойлох” сэдэвт сургалт 2025.05.15-нд 23 байцаагч хамрагдсан. НДЕГазрын ЭММТЗөвлөлөөс , АТГ Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн талаарх ээлжит сургалтад 2025-05-28-нд цахимаар хамрагдсан. | | |
| “Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | | |
| 4.2.1 | Байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | | - Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нийт тоо, хамруулсан хүний тоо. Үүний дотор:<br>- Төрийн албан хаагчийн ес зүйг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан тоо, хамрагдсан | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 44 төрлийн сургалтад давхардсан тоогоор 840 албан хаагчийг хамруулсан. | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон газар, орон нутгийн байгууллагаас зохион байгуулсан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх 28 удаагийн цахим болон танхимын сургалтанд давхардсан тоогоор 500 албан хаагчдыг хамруулан ажилласан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон хэлтэс, орон нутгийн байгууллагаас зохион байгуулсан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх **22** удаагийн цахим болон танхимын сургалтад давхардсан тоогоор **290** албан хаагчдыг хамруулсан. | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүний тоо<br>- Монгол бичгийн сургалт зохион байгуулсан тоо, хамрагдсан хүний тоо<br>- Сургалт хариуцсан мэргэжилтний шинээр санаачлан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо<br>- Сургалт хариуцсан мэргэжилтний ажлын байрны тогтвор суурьшил, идэвхи, ажлын хандлага | | | | | |
| 4.2.2 | Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчлэн найруулга/ батлагдан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад | | - Ажил олгогчид чиглэсэн сургалтын тоо, хамрагдсан хүний тоо<br>- Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэд, малчдад чиглэсэн | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 244 удаагийн сургалтад 19630 иргэд, даатгуулагчийг хамруулсан. | ААН албан байгууллага, иргэд даатгуулагчид чиглэсэн сургалтын хүрээнд 135 удаагийн сургалтаар 96 нэгжид сургалт уулзалт хийж, 10800 иргэд, даатгуулагчид сургалт, уулзалтад хамрагдуулан ажилласан байна. | ААН албан байгууллага, иргэд даатгуулагчид чиглэсэн сургалтын хүрээнд 135 удаагийн сургалтаар 96 нэгжид сургалт уулзалт хийж, 10800 иргэд, даатгуулагчид сургалт, уулзалтад хамрагдуулан ажилласан байна. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчлэн найруулга/ батлагдан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах; | | сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх сургалтын тоо, хамрагдсан хүний тоо<br>- Оюутан сурагчдад зориулсан нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | | | нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр хагас жилийн байдлаар 98 удаагийн сургалтаар 6522 иргэд даатгуулагчдад сургалт, мэдээлэл хүргэн ажилласан.<br>Үүнээс:<br>Ажил олгогч, албан байгууллагат-28 удаагийн сургалтаар 2528 иргэд хамруулсан,<br>Баг, хороонд 21 удаагийн сургалтаар 832 иргэн хамруулсан, Оюутан сурагчдад зориулсан нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах сургалтыг 5 удаа зохион байгуулж 320-н оюутан сурагч хамруулсан, Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэд, малчдад чиглэсэн сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх сургалтыг 44 удаа зохион байгуулж 2836 иргэн хамруулсан байна. | | |
| 4.2.3 | Нийгмийн даатгалын ач холбогдол, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчлэн найруулга/ батлагдан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | . | - Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулахаар орон нутагт зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл<br>- Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-нд мэдээлэл байршуулсан тоо, хандалтын | Нийгмийн даатгалын газар нь өөрийн цахим хуудас www.hentii.ndaatgal.mn веб сайт, www.facebook.com/NDKHenti фэйсбүүк, “Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар“ пэйж хуудсаар 111 мэдээлэл, постер оруулсан. ХНХЯам, НДЕГазраас бэлтгэсэн сурталчилгаа, мэдээ, мэдээллийг цахим сүлжээ | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд шуурхай хүргэсэн байна. | Нийгмийн даатгалын байгууллагын “фэйсбүүк хуудас ажиллуулах журам"-ийн дагуу “Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар“ фэйж хуудсаар 50 мэдээлэл, постер оруулж давхардсан тоогоор 249 мянга гаруй иргэд даатгуулагчдад хүрсэн байна. “Хэнтий мэдээ” сонинтой 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр №19 гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд гэрээний 1 дүгээр хавсралтын дагуу 4-н удаагийн шууд дамжуулалт, 16-н постер, 11-н мэдээ, мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэн ажилласан. | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | — | | тоо<br>- Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо<br>- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, даатгуулагчид, ажил олгогчид мэдээлэл түгээхээр зохион байгуулсан арга хэмжээний төрөл, сурталчилгаа хийсэн тоо<br>- Зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл | ашиглан олон нийтэд түгээсэн ба давхардсан тоогоор 256 мянга гаруй иргэд даатгуулагчдад хүрсэн. | | | | |
| "Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | | |
| "Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.3 | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамжийн хэвийн ажиллагаа хангагдсан байх | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд 2 ажлыг зохион байгуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2015.12.07-ны өдөр баталсан “Сервер компьютерт оны эцсийн үйлчилгээ хийх журам” -ын дагуу 2024.02.15-ны өдөр хуваарьт хугацаандаа мэдээллийн технологийн төвөөр оны эцсийн үйлчилгээг хийлгэж, үйлчилгээний тойрох хуудсыг хөтөлж мэдээллийн технологийн төвд хүргүүлсэн. | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамж, серверийн найдвартай ажиллагааг хангаж гэмтэл, саатал гарсан тохиолдолд түргэн шуурхай илрүүлж хэвийн ажиллагааг хангах арга хэмжээг авсан байна. | Байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах хүрээнд тус газрын байранд сервер 1, router 1, шилэн кабелийн төхөөрөмж 2, конвертер 1, wifi төхөөрөмж 3, switch 8, kiosk төхөөрөмж 1, Танилцуулга, мэдээлэл хүргэх, цахимаар үйлчилгээ авах дижитал дэлгэц 1, цаг бүртгэлийн төхөөрөмж 1, видёо мэдээлэл, шторк мэдээлэл хүргэх дэлгэц 1, үнэлгээний төхөөрөмж NVR 1, камер 7, Дохиолол хамгаалалт, хяналтын камерын тоног төхөөрөмжүүд Үүнд: Дохиоллын станц, Мэдээ дамжуулагч, дуут дохиологч, NVR бичигч 2, свич 2, Гадна камер 7, дотор камер 10, утаа мэдрэгч 18, компьютер 27, принтер газарт 17, сумдад компьютер, принтер 21-ыг ашиглаж байна. Дээрх тоног төхөөмжүүдийн хэвийг байдлыг өдөр бүр шалгаж эвдэрч гэмтэх, доголдол гарах бүрт шуурхай засварлаж хэвийн ажиллааг хангаж ажилласан. Үүнд: 5 удаа компьютер формаж, хэрэглээний программууд болон, үйлчилгээ, үйл ажиллагааны зориулалтын программ хангамжуудыг суулгасан. Лицэнз дууссан windows систем, Microsoft office программын сунгалт 15, Сүлжээний доголдол засварлах ажил 14, конверт гэмтэж эвдэрсэн 1 тохиолдол гарч төхөөрөмж шинээр авч хэвийн ажиллагаанд оруулсан. Принтер тохиргоо, засвар үйчилгээг 25 удаа хийсэн. Хуучин сервер төхөөмжийн үйлдлийн систем гэмтэж хуучин программ хангамжууд ажиллахгүй болсныг “Мэдээллийн технологийн төв”-д хандаж хэвийн ажиллагаанд оруулсан. Шинэ веб программ, ажлын хэрэглээний чат, мэйл бусад программ хангамжийн хэвийн ажиллагааг өдөр өдөр тутамд шалгаж тухай бүр | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохиргоо, засвар үйлчилгээг хийж ажилласан. Цаг бүртгэлийн төхөөрөмжөөс хэвийн ажиллагааг өдөр бүр хянаж бүртгэлийн мэдээллийг “Able, ERP” программд татуулж ажиллаж байна. | | |
| | | | Нэгжид ашиглагдаж буй програм хангамжуудын шинэчлэлт өөрчлөлт цаг хугацаандаа хийгдсэн байх. | | Нэгжид ашиглагдаж буй програм хангамжуудын шинэчлэлт, өөрчлөлтийг цаг тухайд нь хийж байцаагч ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Нэгжид ашиглагдаж буй программ хангамжуудын шинэчлэлт, өөрчлөлтийг цаг тухайд нь хийж байцаагч ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | | |
| | | | Оны эцсийн үйлчилгээний журмыг хэрэгжүүлсэн байх | | Нэгжийн сервер компьютерын оны эцсийн тохируулга үйлчилгээг журмын дагуу бүрэн хийж тайланг цаг хугацаанд нь баталгаажуулан МТТ-д ирүүлсэн байна. | Нэгжийн сервер компьютерын оны эцсийн тохируулга үйлчилгээг журмын дагуу бүрэн хийж тайланг цаг хугацаанд нь баталгаажуулан МТТ-д ирүүлсэн байна. | | |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | | |

***Биелэлт – 100/11 100%***

**Тав. Шинээр хэрэгжүүлэх ажил үйлчилгээ**

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **“Тэрбум мод”** үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж мод тарина | | Тарьсан модыг арчилж ургуулсан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **“Тэрбум мод”** үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж хуваарьт газраа нийт **25** мод тарьсан. | | Тус газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж 2025.05.23-ний өдөр хуваарьт талбайд 60ш хайлаас мод тарьсан. | 100% | |
| 5.2 | Албан хаагчидтай хариуцлагын гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийн хяналтын хуудсыг хэрэглэх сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн мэдээллийг олон нийтэд мэдээлэн ажиллана. | | Хариуцлагын гэрээ байгуулсан эсэх | Байцаагч, албан хаагчидтай хариуцлагын гэрээ байгуулан төрийн албан хаагчийн хяналтын хуудсыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2024 онд сахилгын шийтгэл болон арга хэмжээ авагдсан албан хаагч байхгүй болно. | Албан хаагчидтай хариуцлагын гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийн хяналтын хуудсыг хэрэглэх сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн мэдээллийг олон нийтэд мэдээллэсэн байх. | Төвийн болон сумдын байцаагч нартай хариуцлагын гэрээ байгуулан төрийн албан хаагчийн хяналтын хуудсыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хагас жилийн байдлаар хяналтын хуудас хэрэглэж сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй болно. | 100% | |
| 5.3 | “1 байгууллага, 1 шинэлэг санаа” арга хэмжээний хүрээнд “Тэтгэврийн цахим хувийн хэрэг” программ хангамж нэвтрүүлэх | | Цахимжуулсан хувийн хэргийн тоо | Тэтгэврийн хувийн хэргийг цахимд бүртгэх ажлын хүрээнд 14094 хувийн хэргээс 4228 тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулсан. | Тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулснаар иргэд, тэтгэвэр авагчдын тэтгэврийг цахимаар шалгаж, тогтоох, цахим хяналт, шалгалтыг сайжруулах. | Тус газрын 2025 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авч буй 14094 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэрэг, материалыг цахимжуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2025 оны 05 сарын 31-ний байдлаар цахимжуулах ажил 60 хувьтай явагдаж байна. | 80% | |
| 5.4 | Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэгийг дээшлүүлэх “Нэг цаг нэмэх цэнэг” цахим сургалтад төрийн | | Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинар | Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хэнтий ЗДТГазар, орон нутгийн сургалтын | 7 хоног бүрийн 4 дэх өдрийн 15:00 цагийн өмнө мэдээллийг ирүүлж хэвшсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулдаг төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэгийг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтад нийт албан хаагчдыг хамруулсан. Нийт 22 удаагийн цахим | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдыг хамруулж, түвшин хагас, бүтэн жилээр тогтоох. | | сургалтад тогтмол хамруулах | байгууллагуудаас нийт 44 удаагийн сургалт мэдээлэл авснаар давхардсан тоогоор 840 байцаагч, албан хаагч хамрагдсан. | | болон танхимын сургалтад давхардсан тоогоор 290 албан хаагч оролцсон байна. | | |
| 5.5 | Аймгийн удирдлагууд болон харьяа хэлтсийн дарга, мэргэжилтнээс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах. | | Хугацаанд нь биелэлтийг хангаж ажиллах. | Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан, шуурхай хуралдаан, орон нутгаас зохион байгуулсан бусад арга хэмжээнд тогтмол оролцож, хэвшсэн байна. 2024 онд Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу 33 удаагийн сургалтад хамрагдсан. | Хугацаанд нь биелэлтийг хангаж ажилласан байх | Тус газарт 2025 оны хагас жилийн байдлаар Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газраас сургалтад хамрагдах 8 удаагийн албан бичгийг хүлээн авч 7 удаагийн сургалтад холбогдох мэргэжилтнүүдийг бүрэн хамруулсан. Мөн "Бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал зүүн бүсийн зөвлөгөө"-нд 21 албан хаагч хамрагдсан. Засаг даргын Тамгын газраас Удирдах ажилтны өргөтгөх хурлыг сар бүрийн долоо хоногийн Мягмар гариг бүрийн 14 цагт хуралддаг шуурхай хуралдаанд газрын дарга тогтмол оролцдог. Мөн орон нутгаас зохион байгуулсан бусад арга хэмжээнд тогтмол оролцон ажиллаж байна. | 100% | |
| 5.6 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аймгийн албан ёсны вэб сайт www.khentii.mn , болон " Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар" фэйсбүүк пэйжэд орсон мэдээллийг олон | | Мэдээ, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байх. | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу нийт 43 мэдээ, мэдээллийг цахимд байршуулахаас тус газарт хамааралтай 26 мэдээ, мэдээллийг тухай бүр бүрэн | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аймгийн албан ёсны вэб сайт www.khentii.mn , болон " Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар" фэйсбүүк пэйжэд орсон мэдээллийг олон нийтэд түгээснээр | www.hentii.ndaatgal.mn веб сайт болон www.facebook.com/NDKHenti фэйсбүүк, "Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар" фэйж хуудсаар байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар мэдээ, мэдээлэл, постер оруулж мөн ХНХЯам, НДЕГазраас бэлтгэсэн сурталчилгаа, мэдээ, мэдээллийг иргэд даатгуулагчдад түгээн хүргэж байна. Байгууллагын вэб сайтад чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтэд түгээх | | | байршуулсан байна. | даатгуулагчийн мэдлэг мэдээлэл сайжирсан байна. | байдал, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээлэл, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын мэдээ, мэдээллүүдийг тухай бүр байршуулсан. Шил ажиллагааны shilen.gov.mn -д 2025 оны нэг дүгээр улирлын тайланг 2025.02.24-ний өдөр илгээж 94,3 % үнэлүүлсэн. | | |
| 5.7 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг сар бүр 1-ний дотор харьяа газарт хугацаандаа ирүүлэх | | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг дээд шатны байгууллагад хагас, бүтэн жилээр тайлагнах. | Нийгмийн даатгалын газар нь хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг дээд шатны байгууллагад хагас, бүтэн жилээр бүрэн тайлагнадаг. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг дээд шатны байгууллагад тайлагнаж хүргүүлэх. | Манай байгууллага нь хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг дээд шатны байгууллагадаа хагас, бүтэн жилээр тайлагнадаг бөгөөд сар бүрийн 1-ний дотор тайлагнах хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт байхгүй болно. | 100% | |
| *Биелэлт – 680 /7 97,1 %* | | | | | | | | |
| *Нийт үнэлгээ 492,1 /5 98,4 %* | | | | | | | | |

## ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТЭС